



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/015/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2025 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Бадрал Утас: 91983443 Цахим хаяг: badralts@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>Товчилсон үгийн жагсаалт</b> .....	<b>2</b>
<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>3</b>
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>10</b>
3.1 Албан шаардлага.....	11
3.2 Зөвлөмж.....	11
3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал .....	11
3.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал.....	11
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>14</b>
<b>5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл</b> .....	<b>16</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

## 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ

БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ж.БУМБАТ ТАНАА

### **Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1, 60.3.6, 60.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, 39.3, 39.3.1, 39.4, Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.3, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2.7, Засгийн газрын 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.6, 4.3.6.11, 4.10.1.4 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогоос 2024 онд 6,988.6 мянган төгрөгийн орлого орсон байхад 2025 онд “Хоршоологчдыг дэмжих сургалт”-д 5,175.0 мянган төгрөг зарцуулж журамд заасан сургалтад зарцуулах хязгаараас 3,078.4 мянган төгрөгийг илүү зарцуулсан;
- ✓ Буянтын хөгжил чуулга уулзалт, тариаланчдын зөвлөгөөн зэрэг арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд тэмцээн уралдаан, бараа материал худалдан авахад 22,000.0 мянган төгрөг зарцуулсны анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй, бэлэн мөнгөний кассын тайлан гаргаагүй;
- ✓ Цагдаагийн газарт автомашин худалдан авах гэрээ байгуулахдаа гэрээнд барьцаа байршуулахаар тусгасан байхад санхүүжилтийг бүрэн олгосон;

- ✓ Цагдаагийн хэсэгт автомашин худалдан авсан бөгөөд хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй-23.0 сая, Хятад улсаас худалдан авсан багаж хэрэгслийг ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй-5.0 сая, Цахим Ховд хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж худалдан авсан бөгөөд тоног төхөөрөмжийг дутуу тусгасан-5.0 сая төгрөг, нийт 33,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- ✓ Ахмад эмэгтэйчүүдийг хамгаалах хөтөлбөрөөс тэмцээн уралдаан, магадалшгүй ажлын зардлаас наурьзын баярын бөхийн шагналд зарцуулах гэх мэт урсгал үйл ажиллагааны зардалд 12,500.0 мянган төгрөгийг зарцуулсан;
- ✓ Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ-ийн хөрөнгө оруулалтад тус бүр 10 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд гэрээ байгуулан худалдан авалт хийхдээ хүлээн авсан актгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээ дүгнээгүй;
- ✓ Соёлын төвийн сандал нийлүүлэх тендерт шалгарсан компанитай 33.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан байхад 55.0 сая төгрөг олгохоор шүүх дээр эвлэрсэн бөгөөд 55.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээ болон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт байхгүй байна.аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Буянт сум нь 2025 оны байдлаар 3,783 хүн амтай, 149 төрийн албан хаагчтай, 839 өрхтэй, 736 малчин өрхтэй, 1081 малчинтай, жилийн эцсийн мал тооллогоор 214,840 толгой мал тоолуулжээ.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Буянт сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 1,052,708.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 146,961.5 мянган төгрөг буюу 12.2 хувиар дутуу бүрдүүлсэн байна. Тайлант онд 100.0 сая төгрөгийн татварын бус орлого төлөвлөсөн ч биелээгүй байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын Засаг даргаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хүрээнд нэгдүгээр хавсралтаар 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ, хоёрдугаар хавсралтаар 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 87.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,184,324.75</b>	<b>1,219,287.34</b>
2	1.1.1 Мөнгөн хөрөнгө	725,763.24	250,720.72
3	1.1.3 Авлага	237,582.61	358,441.9
4	1.1.4 Урьдчилгаа	148,730.5	519,600.32
5	1.1.5 Бараа материал	68,648.4	81,701.4
6	1.1.6 Нөөцийн Бараа	3,600.0	8,823.0
<b>7</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,767,100.35</b>	<b>5,051,351.6</b>
<b>8</b>	<b>1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,767,100.35</b>	<b>5,051,351.6</b>
9	1.2.2.02 Биет хөрөнгө	4,420,754.95	4,705,006.2
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	346,345.4	346,345.4
<b>11</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>5,951,425.11</b>	<b>6,270,638.95</b>
<b>12</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,984.26</b>	<b>121,734.4</b>
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,984.26	121,734.4
14	2.1.1.03 Өглөг	2,984.26	121,734.4
<b>15</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,948,440.85</b>	<b>6,148,904.54</b>
<b>16</b>	<b>2.2.1 Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,948,440.85</b>	<b>6,148,904.54</b>
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	781,027.47	781,027.47
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	4,865,206.59	5,065,670.28
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,206.79	302,206.79
<b>20</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>5,951,425.11</b>	<b>6,270,638.95</b>

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>4,201,491.39</b>	<b>2,726,270.86</b>
<b>2</b>	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,001,275.63</b>	<b>1,037,581.5</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	523,611.93	493,781.67
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	539,996.93	533,783.25
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-16,385.0	-40,001.58
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	269,282.21	458,438.37
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	208,381.49	85,361.46
<b>8</b>	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,741,334.28</b>	<b>1,688,689.36</b>
9	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	1,320.0	0.0
10	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	610,024.86

11	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,458,881.48	0.0
<b>12</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,106,609.39</b>	<b>2,535,017.73</b>
<b>13</b>	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,106,609.39</b>	<b>2,535,017.73</b>
<b>14</b>	<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,073,810.81</b>	<b>2,392,704.02</b>
15	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	769,103.74	907,964.89
16	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,699.97	114,526.12
17	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	262,827.9	460,298.29
18	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	384,100.34	354,416.39
19	1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	4,273.0
20	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	12,986.05	15,192.18
21	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,314.0	8,517.3
22	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,239.4	47,722.08
23	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	503,985.72	479,793.76
<b>24</b>	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,798.58</b>	<b>142,313.72</b>
<b>25</b>	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,094,882</b>	<b>191,253.13</b>
<b>26</b>	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>2,094,882</b>	<b>191,253.13</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Дансны нэр, төрөл	Мянган төгрөгөөр	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,562,548.18</b>	<b>2,092,066.94</b>
<b>2</b>	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,001,275.63</b>	<b>1,037,581.5</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	523,611.93	493,781.67
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-16,385	-40,001.58
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	269,282.21	458,438.37
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	208,381.49	85,361.46
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	21,997.43	12,489.42
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	155,653.77	42,526
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	30,730.29	30,346.04
<b>10</b>	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>102,391.07</b>	<b>1,054,485.44</b>
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	101,071.07	99,697.15
12	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	1,320	0.0
13	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	645,015.49
14	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	309,772.8
<b>15</b>	<b>1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,458,881.48</b>	<b>0.0</b>
<b>16</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,496,383.7</b>	<b>1,784,024.09</b>

17	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,496,383.7</b>	<b>1,784,024.09</b>
18	<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,463,585.13</b>	<b>1,641,710.37</b>
19	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,193.95	910,823.67
20	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,423.69	111,213.32
21	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	262,827.9	449,898.53
22	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	29,025.91	31,300.91
23	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	204.8
24	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	12,986.05	15,485.08
25	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,314	8,517.3
26	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,607.48	48,614.8
27	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	212,652.44	65,651.97
28	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,798.58</b>	<b>142,313.72</b>
29	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,066,164.48</b>	<b>308,042.85</b>
30	<b>1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>474,710.12</b>	<b>654,760.37</b>
31	<b>1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>474,710.12</b>	<b>654,760.37</b>
32	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	474,710.12	654,760.37
33	<b>1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-474,710.12</b>	<b>-654,760.37</b>
34	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨР ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,470	128,325
35	<b>1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-2,470</b>	<b>-128,325</b>
36	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>588,984.36</b>	<b>-475,042.52</b>
37	<b>1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>136,778.88</b>	<b>725,763.24</b>
38	<b>1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>725,763.24</b>	<b>250,720.72</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	ЗГ-ын хувь оролцооны дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	<b>1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,853,558.85</b>	<b>3,853,558.85</b>
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,853,558.85	3,853,558.85
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	2,094,882.00	2,094,882.00
4	<b>1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,948,440.85</b>	<b>5,948,440.85</b>
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,948,440.85	5,948,440.85
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,210.57	9,210.57
7	<b>1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,957,651.42</b>	<b>5,957,651.42</b>
8	1.7 Тайлант үеийн үр дүн	191,253.13	191,253.13
9	<b>1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>6,148,904.54</b>	<b>6,148,904.54</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	1	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,151,707.5</b>	<b>2,008,471.8</b>
2	11	<b>3.1.01.1.1 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,092,169.5</b>	<b>1,037,581.5</b>
3	110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	467,115.4	493,781.7
4	1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	507,117.0	533,783.2
10	1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(40,001.6)	(40,001.6)
12	113	3.1.01.1.1.1.3 Хөрөнгийн албан татвар	446,110.5	458,438.4
16	118	3.1.01.1.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	178,943.6	85,361.5
17	1180	3.1.01.1.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,000.0	12,489.4
21	1181	3.1.01.1.1.1.8.2 Газрын төлбөр	64,943.6	42,526.0
23	1182	3.1.01.1.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	79,000.0	30,346.0
27	12	<b>3.1.01.1.2 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,059,538.0</b>	<b>970,890.3</b>
28	120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	107,500.0	15,126.7
32	122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	561,420.4	561,420.4
35	123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	309,772.8	309,772.8
37	II	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,785,398.3</b>	<b>2,509,871.8</b>
38	21	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,761,694.7</b>	<b>1,726,786.4</b>
39	210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,737,312.7	1,584,472.7
40	2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,005,996.1	910,823.7
45	2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,196.9	111,213.3
51	2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	464,447.3	446,962.1
55	2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	28,292.0	23,013.3
59	2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.2	204.8
61	2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	16,155.0	15,485.1
64	2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	9,364.1	8,517.3
66	2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,784.4	46,860.8
73	2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	25,393.7	21,392.3
76	213	<b>3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,382.0</b>	<b>142,313.7</b>
77	2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	125,865.9
80	2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	24,382.0	16,447.8
83	22	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>885,557.5</b>	<b>654,760.4</b>
87	23	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>138,146.1</b>	<b>128,325.0</b>
89	8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	633,690.8	501,400.0
90	9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(633,690.8)	(501,400.0)
91	7	<b>3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(633,690.8)</b>	<b>(501,400.0)</b>
92	4	<b>4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>701,852.3</b>
93	5	<b>5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>200,452.3</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>228,484.88</b>	<b>83,595.09</b>
12	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>228,484.88</b>	<b>83,595.09</b>
122	<b>1.1.1.1.1.1 Тусламжийн орлого</b>	<b>228,484.88</b>	<b>83,595.09</b>
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	228,484.88	83,595.09
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	228,484.88	83,595.09
II	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>228,484.88</b>	<b>36,901.16</b>
21	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>228,484.88</b>	<b>36,901.16</b>
210	<b>1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>208,148.44</b>	<b>36,901.16</b>
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	2,936.36
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	500.00	8,287.60
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,940.00	1,753.96
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	199,708.44	23,923.20
213	<b>1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,336.43</b>	<b>46,693.93</b>
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	20,336.43	46,693.93
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	46,693.93
6	1.ХАРИЛЦАХ БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ДАНСНЫ ЦЭВЭР ӨӨРЧЛӨЛТ	0	(46,693.93)

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,112,750.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 981,072.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

### Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:

- Санхүүгийн байдлын тайланг зөрүүтэй илэрхийлсэн – 57,149.9 мянган төгрөг,
- Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй тайлагнасан -2,045.8 мянган төгрөг,
- Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй – 159,136.7 мянган төгрөг,

### Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- Санхүү байдлын тайланд урьдчилж гарсан зардлыг дутуу тусгасан – 381,369.8 мянган төгрөг,
- Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй тайлагнасан– 347,620.6 мянган төгрөг,
- Санхүү байдлын тайланд өр төлбөрийг дутуу бүртгэсэн – 33,749.2 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 16,477.6 мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 131,678.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 22,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 109,678.4 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Буянтын хөгжил чуулга уулзалт, тариаланчдын зөвлөгөөн зэрэг арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд тэмцээн уралдаан, бараа материал худалдан авахад 22,000.0 мянган төгрөг зарцуулснаас анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын хоёр дугаар зүйлийн 3-д “Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөн гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ.” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

### 3.2 Зөвлөмж

#### 3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2024 онд Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогоос 6,988.6 мянган төгрөгийн орлого орсон байхад 2025 онд “Хоршоологчдыг дэмжих сургалт”-д 5,175.0 мянган төгрөг зарцуулж журамд заасан сургалтад зарцуулах хязгаараас 3,078.4 мянган төгрөгийг илүү зарцуулсан нь “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.7-д “Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 30 хүртэл хувийг хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад” зарцуулна гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн мөнгөн хөрөнгийг “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хүүгийн орлогоос зарцуулах хэмжээг баримтлан зарцуулж, хяналт тавьж ажиллах.

#### 3.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

3.2.2.1 Илрүүлэлт: Цагдаагийн газарт автомашин худалдан авах гэрээ байгуулахдаа гэрээнд барьцаа байршуулахаар тусгасан байхад санхүүжилтийг бүрэн олгосон нь Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.3-д “Барьцаа үүсэх үед тодорхойлж болох ирээдүйд бий болох, болзол тавьсан шаардлагыг, эсхүл талуудын харилцан тохиролцсон аливаа үүргийг хангахад барьцааг хэрэглэж болно” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах гэрээнд тусгасан аливаа эрх, үүрэг, нөхцөлийн дагуу санхүүжилтийг олгох, байгуулсан гэрээг мөрдөх.

3.2.2.2 Илрүүлэлт: Цагдаагийн газарт автомашин худалдан авсан бөгөөд хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй – 23,000.0 мянган төгрөг, Хятад улсаас худалдан авсан багаж хэрэгслийг

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй – 5,000.0 мянган төгрөг, Цахим Ховд хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж худалдан авсан бөгөөд тоног төхөөрөмжийг дутуу тусгасан-5,000.0 мянган төгрөг, нийт 33,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг эхний хагас жилийн тайланд бүртгэх.

**3.2.2.3 Илрүүлэлт:** Ахмад эмэгтэйчүүдийг хамгаалах хөтөлбөрөөс тэмцээн уралдаан, магадалшгүй ажлын зардлаас наурызын баярын бөхийн шагналд зарцуулах гэх мэт урсгал үйл ажиллагааны зардалд 12,500.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно” 60.3.1-д “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.4-д “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт тухайн засаг захиргааны нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй”, 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасантай, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Урсгал үйл ажиллагаанд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахгүй байх, иргэдийн санал авч эрэмбэлээгүй ажлыг төлөвлөхгүй байх.

**3.2.2.4 Илрүүлэлт:** Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ-ийн хөрөнгө оруулалтад тус бүр 10 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд гэрээ байгуулан худалдан авалт хийж санхүүжилт олгохдоо хүлээн авсан актгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээ дүгнээгүй нь Засгийн газрын 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.6-д “Төсөл арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилт нь гэрээний нийт дүнгийн үлдэгдэл буюу хамгийн багадаа 10 хувиас багагүй байх ба эцсийн санхүүжилтийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын дүгнэлт гарсны дараа олгох бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж, эх хувь гэсэн баримт бичгийн хувьд цаасаар, бусад баримт бичгийн цахим системээр ирүүлнэ”, 4.3.6.11-д “байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт эх хувь”, 4.10.1.4-д “захиалагч нь худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, энэ журмын 9 болон 13 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, , нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг даргын захирамжаар баталсан ашиглалтад хүлээн авах комиссын актын дагуу тоног төхөөрөмж, ажлын санхүүжилтийг олгож, эцсийн тооцоог хийх.

**3.2.2.5 Илрүүлэлт:** Соёлын төвийн сандал нийлүүлэх тендерт шалгарсан компанитай 33.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан байхад 55.0 сая төгрөг олгохоор шүүх дээр эвлэрсэн бөгөөд 55.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээ болон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-д “худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно”, 39.3-д “худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана”, 39.3.1-д “гэрээний үнэ”, 39.4-д “Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний дагуу санхүүжилтийг олгох, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй тохиолдолд гэрээ зөрчихгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Санхүү байдлын тайланд авлага дутуу бүртгэсэн	1	57,149.9	1	57,149.9			1	57,149.9				
Хоршоо хөгжүүлэх сан	Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй тайлагнасан	1	2,045.8			1	2,045.8	1	2,045.8				
Хоршоо хөгжүүлэх сан	Мөнгөн гүйлгээний тайланд орлого зарлагыг дутуу бүртгэсэн	1	159,136.7	1	159,136.7			1	159,136.7				
Орон нутгийн хөгжлийн сан	Санхүү байдлын тайланд урьдчилж гарсан зардлыг дутуу бүртгэсэн	1	381,369.8	1	381,369.8			1	381,369.8				
Орон нутгийн хөгжлийн сан	Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй тайлагнасан	1	347,620.6			1	347,620.6	1	347,620.6				
Орон нутгийн хөгжлийн сан	Санхүү байдлын тайланд өр төлбөрийг дутуу бүртгэсэн	1	33,749.2	1	33,749.2			1	33,749.2				
<b>ДҮН</b>		<b>6</b>	<b>981,072.0</b>	<b>4</b>	<b>631,405.6</b>	<b>2</b>	<b>349,666.4</b>	<b>6</b>	<b>981,072.0</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Орон нутгийн хөгжлийн сан	Буянтын хөгжил чуулга уулзалт, тариаланчдын зөвлөгөөн зэрэг арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд тэмцээн уралдаан, бараа материал худалдан авахад анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй, бэлэн мөнгөний кассын тайлан гаргаагүй,	1	22,000.0			1	22,000.0						

	Цагдаагийн газарт автомашин худалдан авах гэрээ байгуулахдаа гэрээнд барьцаа байршуулахаар тусгасан байхад санхүүжилтийг бүрэн олгосон,	1	-					1	-		
	Цагдаагийн газарт автомашин худалдан авсан бөгөөд хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй-23.0 сая, Хятад улсаас худалдан авсан багаж хэрэгслийг сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй-5.0 сая, Цахим Ховд хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж худалдан авсан бөгөөд тоног төхөөрөмжийг дутуу тусгасан-5.0 сая төгрөг	1	33,000.0					1	33,000.0		
	Ахмад эмэгтэйчүүдийг хамгаалах хөтөлбөрөөс тэмцээн уралдаан, магадалшгүй ажлын зардлаас наурызын баярын бөхийн шагналд зарцуулах гэх мэт урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж байна.	1	12,500.0					1	12,500.0		
	Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ-ийн хөрөнгө оруулалтад тус бүр 10 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд гэрээ байгуулан худалдан авалт хийхдээ хүлээн авсан актгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээ дүгнээгүй	1	40,000.0					1	40,000.0		
	Соёлын төвийн сандал нийлүүлэх тендерт шалгарсан компанитай 33.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан байхад 55.0 сая төгрөг олгохоор шүүх дээр эвлэрсэн бөгөөд 55.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээ болон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт байхгүй	1	21,100.0					1	21,100.0		
Хоршоо хөгжүүлэх сан	2024 онд Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогоос 6,988,600 төгрөгийн орлого орсон байхад 2025 онд "Хоршоологчдыг дэмжих сургалт"-д 5,175,000 төгрөг зарцуулж журамд заасан сургалтад зарцуулах хязгаараас 3,078,404 төгрөгийг илүү зарцуулсан	1	3,078.4					1	3,078.4		
<b>ДҮН</b>		<b>7</b>	<b>131,678.4</b>				<b>1</b>	<b>22,000.0</b>	<b>6</b>	<b>109,678.4</b>	

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		